




ECOSOUМ



The Asia Foundation

ХОГ ХАЯГДЛЫН БҮТЦИЙН СУДАЛГАА НАРИЙВЧИЛСАН ТАЙЛАН



Тайланг бэлтэсэн **Пиэр Гэрбэр**, Экосум ТББ-ын Захирал
Хянасан **Гүрсэдийн Нарантуяа**, Экосум ТББ-ын Тэргүүн

2019 он 8-р сар

ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад, тэр дундаа хөдөө орон нутаг, сумдад хийгдсэн хог хаягдлын бүтцийн тухай судлагаа хомс байдаг. Экосум ТББ Хишиг-Өндөр сумын хогийн цэгт хаягдаж буй хогны хэмжээ, бүтэц зэргийн тухай мэдээлэл олохоор ихээхэн цаг зарцуулсан боловч энэ талаар албан ёсны тоо, мэдээлэл огт олж чадаагүй юм.

Хог хаягдал дахин боловсруулах төслийн хүрээнд Экосум ТББ нь Азийн сангийн дэмжлэгтэйгээр 2019 оны 7-р сард өрхийн хаягдлын бүтцийн судлагааг хийв. Уг судлагаа нь сумын дундаж өрхийн гаргаж буй хаягдлыг бүтцээр нь төрөлжүүлэн, түүнийг нарийвчлан судлах, талбарын ажиглалтыг нарийвчилсан мэдээллээр хангах зорилгоор хийгдсэн.

Судлагааны үр дүнг нарийвчлан шинжилснийг уг тайланд дурдсан болно.

АРГАЧЛАЛ

Экосум ТББ-ын Facebook хуудсанд нийтлэгдсэн зарын дагуу Хишиг-Өндөр сумын төвийн 51 өрх сайн дураар уг судлагаанд оролцохоор бүртгүүлсэн. Жич: сумын нийт өрхийн ихэнх хувь нь Экосум ТББ-ын Facebook хуудсыг дагадаг.

Судлагаанд сайн дураар оролцсон нийт өрхийн зөвхөн 36 нь Экосумын зааварчилгааны дагуу хогоо ангилан ялгасан байсан ба уг судлагаанд сумын төвийн нийт өрхийн (нийт 367¹ өрхөөс 36 нь)10 хувийг түүвэрлэн оролцуулсан болно.

Судлагаа эхлэхээс өмнө бүх өрхүүдэд нарийн зааварчилгаа өгч, хаягдал ангилах уут тараасан. Судлагаанд оролцогч өрхүүд нэг долоо хоногийн турш (2019 оны 7-р сарын 22-28 дуустал) гарч буй бүх хаягдлаа дараах 15 төрлөөр ангиллаа:

1. Цаас;
2. Хуванцар сав (1 номерын буюу ус ундааны сав);
3. Хатуу хуванцар (HDPE, LDPE, PVC);
4. Гялгар уут;
5. Тетрапак савлагаа;
6. Шил;
7. Төмөр (төмөр, хөнгөн цагаан, зэс гм);
8. Хүнс;
9. Даавуу, нэхмэл эдлэл, савхи;
10. Цахилгаан хэрэгсэл;
11. Зай, баттерей;
12. Жорлон болон ариун цэврийн хэрэгсэл;
13. Үнс (боломжтой бол хэмжээг нь тогтоох);
14. Малын өтөг бууц (боломжтой бол хэмжээг нь тогтоох);
15. Бусад.

¹ МУ-ын Статистизийн Мэдээллийн Нэгдсэн Сан (<http://1212.mn>), 2018 он.

² Жилийн өрхийн дундаж орлогыг нийт түүврийн дунджаар бодож гаргахаас өмнө өрх тус бүрт бодож гаргасан

Хаягдал ангилах долоо хоногийн эцэст оролцогч өрхүүд ангилсан хаягдлаа тусгайлан бэлтгэсэн цэгт хүргэн тушаасан ба Экоsum ТББ-ын баг хаягдлыг жинлэн хүлээн авсан. Зарим тохиолдолд Экоsum өрхүүдийн ялгасан хогийг шууд цуглуулан, хаягдлыг жинлэж байв. Шаардлагатай тохиолдол малын өтөг бууцыг өрхийн хашаанд очин жинлэж ойролцоогоор хэмжээг нь тодорхойлсон болно.

Судлагаанд оролцогч өрх бүр асуулга бөглөсөн бөгөөд уг асуулга нь судлагааны өгөгдлийг боловсруулахад шаардлагатай, өрхийн хаягдлын сэдэвтэй 8 үндсэн асуулттай байсан.

Судлагааны асуулгууд:


1. Танай гэр бүл гэрт амьдардаг уу? Эсвэл байшинд амьдардаг уу?
2. Хишиг-Өндөр сумын төвд, өөрийг чинь оролцуулан нийт хэдэн хүн танай гэрт амьдардаг вэ?
3. Танай гэр бүлийн аль нэгэн гишүүн гэртээ/хашаандаа ямар нэг үйл ажиллагаа эрхэлдэг үү? Хэрэв тийм бол ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ?
4. Танай өрхийн нэг жилийн дундаж орлого хэд вэ?
5. Сууцаа хэрхэн халаадаг вэ? Цахилгаанаар, гал түлж, бусад? Хэрэв зууханд гал түлдэг бол зуны улиралд ямар төрлийн түлш хэрэглэдэг вэ: нүүрс, мод, аргал, бусад?
6. Гэртээ хоол хийхдээ ямар халаалтын систем ашигладаг вэ: цахилгаан, зууханд гал түлдэг, эсвэл цахилгаан болон гал түлэх аль аль аргаар, бусад?
7. Хашаандаа амьтан тэжээдэг үү (нохой, мал)?
8. Хашаандаа малтай бол хүнсний хаягдлаа малдаа өгдөг үү?

Өгөгдлийг 2019 оны 8-р сард боловсруулсан ба үр дүнг доор үзүүлэв.

СУДЛАГААНЫ ХАМ СЭДВИЙН ӨГӨГДӨЛ

1. Орон сууцны төрлөөр


Судлагаанд түүвэрлэгдсэн нийт өрхийн 92 хувь буюу 33 өрх байшинд, харин зөвхөн 8 хувь буюу 3 өрх гэрт амьдардаг.



Түүвэрлэгдсэн өрхүүдийн орон сууцны задаргаа байшин болон гэрээр

2. Нэг өрх дэх бүлийн тоо


Дунджаар нэг өрх 3.9 ам бүлтэй ба бүтцийн хувьд 2.4 насанд хүрэгч, 1.5 хүүхэд амьдардаг байна.



Түүвэрлэгдсэн өрхийн ам бүл дэх насанд хүрэгсдийн тоо

3. Хашаан дахь үйл ажиллагаа эрхлэлтийн байдал

Түүвэрлэгдсэн нийт өрхүүдийн 11 хувь буюу 4 өрх хашаандаа аль нэг төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд үүнд: 1 өрх үхэр тэжээх, 1 өрх гахай тэжээх болон төмрийн дархан, 1 өрх хүлэмжинд өргөст хэмх тариалах, 1 өрх механик засвар хийдэг.



Хашаандаа мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг өрхүүд хувиар

4. Дундаж орлого

Түүвэрлэгдсэн хүн амын жилийн дундаж орлого 7.5 сая төгрөг ба өрх бүр дэх насанд хүрэгч тутамд ногдох жилийн дундаж орлого 3.5 сая төгрөг болж байгаа юм.²

Түүвэрлэгдсэн нийт өрхийн 44 хувь буюу 16 өрхийн орлого 5-аас 10 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан бол 36 хувь буюу 13 өрхийн жилийн орлого 5 хүртэлх сая, харин үлдсэн 20 хувь буюу 7 өрх 10-аас дээш сая төгрөгийн орлоготой байсан.




Түүвэрлэгдсэн өрхийн жилийн дундаж орлогын хувь.

5. Халаалтын систем

Судлагаанд оролцсон бүх 36 өрх гэрээ зууханд гал түлж халаадаг ч зуны улиралд аль нь ч нүүрс хэрэглэдэггүй байна.

Гэрээ хөнгөн хэлбэрээр буюу богино хугацаанд халаахдаа 83 хувь буюу 30 өрх нь мод, 14 хувь (5 өрх) нь мод болон аргал, зөвхөн 3 хувь (1 өрх) нь аргал түлдэг гэж хариулжээ.




Зуухандаа мод, аргал эсвэл хоёуланг нь хэргэлдг өрхүүд хувиар.

² Жилийн өрхийн дундаж орлогыг нийт түүврийн дунджаар бодож гаргахаас өмнө өрх тус бүрт бодож гаргасан болно. Хэрэв бид өрхийн дундаж орлогыг өрх бүр дэх нэг насанд хүрэгчид ногдох тоог гаргасан бол энэ нь нэг насан хүрэгчид 3.1 сая төгрөг ногдож байгаа юм.

6. Хоол бэлтгэх систем


Түүвэрлэгдсэн өрхийн 81 хувь (29) нь хоолоо ихэнхдээ цахилгаан зууханд хийдэг бол 11 хувь буюу 4 өрх нь зууханд гал түлж харин 8 хувь буюу 3 өрх үргэлж цахилгаан зуух ашигладаг байна.



Цахилгаан, мод түлдэг зуух эсвэл хоёуланг нь ашиглан хоол хийдэг өрхүүд хувиар.

7. Зуны улиралд хашаандаа амьтан тэжээдэг өрхүүд


Зуны цагт түүвэрлэгдсэн өрхүүдийн 53 хувь буюу 19 нь хашаандаа нохой, 8 хувь буюу 3 өрх (2 өрх үнээ тэжээж, 1 өрх гахай тэжээдэг) мал тэжээдэг бол 39 хувь буюу 14 өрх ямар нэг амьтан тэжээдэггүй гэж хариулжээ.



Зуны цагт хашаандаа нохой, мал тэжээдэг эсвэл амьтан тэжээдэггүй өрхүүдийг хувиар үзүүлсэн байдал.

8. Хоолны хаягдлаа тэжээвэр амьтанд өгдөг өрхүүд

Нийт өрхүүдийн 22 нь хашаандаа амьтан тэжээдэгээс зөвхөн 7 өрх буюу 32 хувь нь хоолны хаягдлаа тэжээвэр амьтандаа өгдөг гэж хариулсан.



Хашаандаа амьтан тэжээдэг 22 өрхүүдээс хоолны хаягдлаа амьтанд өгдөг өрхүүдийг хувиар үзүүлсэн байдал

ХОГ ХАЯГДЛЫН БҮТЭЦ: ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Малын баас буюу аргал, хомоол

15 төрлийн хаягдал дунд аргал/хомоол нь өвөрмөц байр суурь эзэлдэг. Нийт түүвэрлэгдсэн өрхийн зөвхөн 3 буюу 8% нь хашаандаа малтай ба малынхаа аргалыг хураадаг. Тодруулбал, эхний өрх 10 үнээтэй, тэдгээрээс долоо хоногт 140 кг орчим аргал гардаг. Хоёр дахь өрх 7 гахайтай ба долоо хоногт 70 кг орчим өтөг гардаг бол гурав дахь өрх 2 үнээтэй ба долоо хоногт 80 кг орчим аргал гардаг байна.

Дээрх дээр үндэслээд аргалыг хаягдал гэж үзвэл нийт хаягдлынх нь 97 орчим хувийг малын аргал/хомоол хаягдал эзэлж байгаа юм. Нийт судалгаанд оролцогч 36 өрхийг (малгүй эсвэл аргалан хаягдалгүй 33 өрхийг) оролцуулсан ч малын аргалан хаягдал нийг хаягдлын дунджаар 70 орчим хувийг эзэлж байна. Энэ өгөгдөл нь бидний судлагааны дүн шинжилгээг үргүйдүүлэн, шууд нөлөөлж байгаа тул Хишиг-Өндөр сумын төвийн өрхүүдийн хаягдлын менежментийн гол асуудал нь малын аргал/хомоол гэж дүгнэж болно.

Хишиг-Өндөр сумын төвийн өрхүүдийн хаягдлын бүтцийн ихэнх хувийг эзэлж буй малын аргалыг хэмжээг бууруулах, цаашлаад ахуйн хаягдлын ангилалд оруулахгүйн тулд дараах зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй.

Нэгдүгээрт, аргалын жин улирлаас хамааран харилцан адилгүй байдаг. Шинэ нойтон аргал нь хуурай аргалаас хүнд байдаг. Жишээ нь хашаандаа 10 үнээтэй өрхийн 1 үнээнээс 1 өдөрт 2 кг орчим аргал гарсан байхад 2 үнээтэй өрхийн 1 үнээнээс 1 өдөрт нөгөө өрхийн үнээний аргалаас даруй 3 дахин их буюу 6 кг аргал гарна. Иймээс дээрх өрхүүдийн үнээнээс 1 өдөрт гарсан аргалын жингийн хувьд аль нь бодит жин болохыг хэлэхэд бэрх.

Хоёрдугаарт, хашаандаа амьтан тэжээдэг 3 өрхийн 2 нь (10 үнээтэй болон гахай тэжээдэг өрхүүд) хашаандаа амьтан тэжээж буйгаа үндсэн ажил, орлогын эх үүсвэр гэж үздэг. Иймээс малын аргал өтгийг ахуйн хаягдал гэхээс илүү үйлдвэрлэлийн хаягдал гэж үзэж болохоор байна.


Хамгийн чухал нь МУ-ын хуулинд “өмчлөгчид цаашид хэрэгцээгүй болсон эд зүйлсийг хаягдал гэнэ³” гэж заасан байдаг тул малын баасыг хаягдал гэсэн ангиллаас хасах хэрэгтэй. Бидний судалгаанд оролцогч өрхүүд аргалаа хатаан, дараа нь түлш болгон ашигладаг гэж асуулгад хариулсан мөн 2 үнээтэй өрхийн хувьд хашааныхаа гаднаас аргал түүж зуухаа галлахад хэрэглэдэг тул аргалыг хаягдал гэж ангилах нь зохисгүй юм.

Эцэст нь, гахайн өтгийг үйлдвэрлэлийг хаягдал, үхрийн аргалыг хаягдал гэж ангилах нь судлагааны мэдээллийг зохистой боловсруулан үр дүнг нарийн шинжлэхэд хүндрэл учруулж байгаа тул аргал, өтгийг судлагаанаас хасан, энэ тайланд дахин дурдаагүй болно.

Долоо хоног хураасан ахуйн хаягдалын дундаж жин


Аргал, хомоолыг үл оролцуулбал, нэг өрхөөс долоо хоногт дунджаар 3.7 кг орчим хаягдал гардаг байна. Үүнийг өрхийн ам бүлийн тоотой харьцуулахад долоо хоногт 1 хүнээс 1.1 кг хаягдал, насанд хүрсэн 1 хүнээс 1.8 кг орчим хаягдал гарч байгаа юм.

³ Хог хаягдлын тухай хууль, Зүйл I, § 4.1.1, Улаанбаатар хот, 2017 он, Монгол Улс.



Нэг өрхийн нэг насанд хүрсэн хүнээс гарч буй хаягдал дунджаар үзүүлсэн байдал (кг)

Ахуйн хаягдлын бүтэц



Түүвэрлэгдсэн өрхүүдийн хаягдлыг ангилал тус бүр дээр нь хувиар илэрхийлсэн байдал (аргал, хомоол ороогүй болно)


Аргалыг үл оролцуулбал шил (жингийн хувьд) ахуйн хаягдлын хамгийн их хувь буюу 27%, хоёрдугаарт, хуванцар 20% түүний тал хувийг PET хуванцар эзэлж байна. Хүнсний хаягдал гуравдугаарт (14%) жагссан бол үнс (8%), цаасан хаягдал (6%), даавуун хаягдал (4%) багахан хувийг эзэлж, метал (1.1%), цахилгаан барааны хаягдал (0.7%), тетрапак савлагаа (0.4%) болон зай (0.1%) буюу бараг байхгүйтэй адил байна. дээрх 15 ангилалд багтаагүй хаягдал (мод, холимог болон танигдаагүй материал) нийт ахуйн хаягдлын 8%-ийг эзлэсэн байна.

Түүнээс гадна:

- Жингээр авч үзвэл шил хамгийн их хувийг эзлэсэн бол хөнгөхөн, зай бага эзлэдэг ч хэмжээний хувьд хуванцарын хаягдал хамгийн их цугларсан, дээр нь алслагдсан сумдаас хот суурин дахь хаягдал боловсруулах үйлдвэрүүд рүү хаягдал тээвэрлэх тээвэрлэлтийн зардал нь нэг машинд ачих хаягдлын хэмжээнээс хамааралтай байдаг учир хаягдал боловсруулах асуудалд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэх нь зүйтэй.
- Судлагаанд оролцогч нийт өрхүүдийн зөвхөн 7 өрх (20%) нь мал, амьтандаа хоолны хаягдал өгдөг гэсэн тул дээрх графикт үзүүлсэн хүнсний хаягдал нь бодит хаягдлыг илэрхийлж байгаа.
- Нийт оролцогч өрхүүдийн зөвхөн 12 нь үнсний хаягдлаа авчирсан тул хэмжээ нь бодит байдлаас дутуу үнэлэгдсэн байх магадлалтай. Учрыг лавдахад ихэнх нь зуны цагт гал түлээгүй (89% нь цахилгаан зуухан дээр хоолоо хийдэг, гэрээ дулаацуулах зорилгоор л гал түлдэг) гэж хариулсан ч зарим өрхүүд гал түлсэн ч бидэнд мэдэгдээгүй байх магадлалтай юм.
- Ариун цэврийн хаягдлын хэмжээ мөн л багцаагаар гарсан байх магадлалтай ба дараах хоёр шалтгаантай. Нэгт, өрхүүдийн гуравны нэг нь хаягдлаа авчирч тушаагаагүй, тушаасан ч ариун цэврийн хэрэглэл гэдэгт зөвхөн 00 цаасыг хамруулах нь өрөөсгөл ойлголт, нөгөөтэйгүүр хаягдлаа тушаасан өрхүүдийн ариун цэврийн хаягдал нойтон, хүнд байсан нь бороонд норсноос болсон байх магадлалтай тул бодит жинг нарийн мэдэхэд бэрхшээлтэй байсан. Хамгийн хүнд буюу 3 кг жинтэй хаягдал тушаасан 2 өрхийн хувьд ариун цэврийн хаягдал нь хүүхдийн живх голдуу байсан бөгөөд зориулалтын уутанд хийсэн байсан нь судлагааны дүнд нөлөөлөхгүй гэж бид дүгнэсэн. Гэсэн хэдий ч хүүхдийн живхний хаягдлын хэмжээ нь хүүхдийн живхэн хаягдалгүй өрхүүдийн ариун цэврийн хаягдлыг давж гарахуйц их байсан (түүвэрлэгдсэн хаягдлын 94%-ийг эзэлж байв) гэдгийг онцлох нь зүйтэй.
- Даавууны төрлийн хаягдлын хэмжээ мөн бодит бус байх магадлалтай. Учир нь зөвхөн 1 өрх 2кг орчим даавууны хаягдал авчирсан бөгөөд энэ нь удаан хугацаанд хадгалж байсан даавууны хаягдлаа судлагаанд оролцож байх үедээ хаяхаар шийдсэн байх магадлалтай юм.
- Төмрийн хаягдлын хэмжээн бодит бус, дутуу хэмжигдсэн байх магадлалтай. Учир нь төмрийн хаягдал цуглуулагчид Хишиг-Өндөр сумаар тогтмол дайран өнгөрч төмрийн хаягдал худалдан авдаг тул төмрийн хаягдлыг “үнэт хаягдал” гэж хэлж болох бөгөөд яагаад төмрийн хаягдлын хэмжээ бага байсныг үүгээр тайлбарлаж болно.

Орлогоос хамааралтай ахуйн хаягдлын хэмжээ

Өрхийн орлого ахуйн хаягдалд хэрхэн нөлөөлж байгааг мэдэхийн тулд бид өрхийн орлогыг дараах 3 түвшнээр ангилсан болно. Үүнд: жилд 5 саяаас бага, 5-10 сая төгрөгийн хоорон болон 10 саяаас дээш орлогтой.



Өрхийн орлогоос хамааран ахуйн хаягдлын хэмжээг үзүүлсэн байдал

Нийт хаягдлын түвшинг авч үзэхэд орлого ихсэх тусам хаягдал нь багассан шинжтэй байна. Өрхийн ам бүлийн тоог оролцуулалгүй тооцвол 5-10 сая төгрөгийн хооронд орлоготой өрхүүд (долоо хоногт 4.1 кг) 5 саяаас доош орлоготой (долоо хоногт 3.6 кг) болон 10 саяаас дээш орлоготой (долоо хоногт 3 кг) өрхүүдээс илүү хаягдал гаргаж байсан. Харин өрхийн ам бүлийн гишүүдэд ногдох ахуйн хаягдлыг орлогын түвшинтэй харьцуулан судлахад орлого өндөртэй өрх бага хаягдал гаргадаг нь тодорхой болсон (дээрх хүснэгтээс харна уу).

Хаягдлын бүтцийн тухайд дараах гурван зүйлс ажиглагдсан. Үүнд:

- Орлого ихсэх тусам шилний хаягдал багассан (5 саяаас бага орлоготой өрхүүдийн шилний хаягдал 33% байсан бол 10 саяаас дээш орлоготой өрхүүдийн хаягдлын 19% нь шилний хаягдал байсан).
- Орлого ихсэх тусам хүнсний хаягдлын хувь хэмжээ ихэсч байсан (5 саяаас бага орлоготой өрхүүдийн хүнсний хаягдал 10% байсан бол 10 саяаас дээш орлоготой өрхүүдийн хаягдлын 22% нь хүнсний хаягдал байсан).
- Орлого ихсэх тусам цахилгаан хэрэгслийн хаягдлын хувь хэмжээ ихэсч байсан (5 саяаас бага орлоготой өрхүүдийн цахилгаан хэрэгслийн хаягдал 0% байсан бол 10 саяаас дээш орлоготой өрхүүдийн хаягдлын 4% нь цахилгаан хэрэгслийн хаягдал байсан).

Түүнчлэн тоо мэдээллүүд хоорондоо төстэй эсвэл дундаж буюу 5-10 сая төгрөгийн хооронд орлоготой өрхийн ангилалын өрхүүдийн хаягдал нөгөө 2 ангиллын өрхүүдийн хаягдлаас харьцангуй их эсвэл бага зэрэг шалтгаанаар хаягдлын ангилал тус бүрийн онцлогийг (мөн орлогын түвшинд хамаарах хаягдлын хэмжээний хоорондын уялдааг) тодорхойлоход бэрхшээлтэй байсан.

Түүвэрлэгдсэн өрхүүдийн хаягдлыг ерөнхийд нь харвал жилд 10 сая төгрөгөөс бага орлоготой өрхүүдийн гаргасан хамгийн их хэмжээний хаягдал нь шилний хаягдал байсан бол 10 саяаас дээш орлоготой өрхүүдийн хүнсний хаягдал хамгийн их хэмжээг эзэлж байгаа юм.

Жилийн дундаж орлого	5 сая төгрөгөөс доош	5-10 сая төгрөгийн хооронд	10 сая төгрөгөөс дээш
Цаас	6%	7%	5%
Хуванцар сав (PET)	10%	8%	13%
Хатуу хуванцар	4%	2%	2%
Гялгар уут	11%	6%	10%
Тетрапак	0%	1%	1%
Шил	33%	26%	19%
Төмөр	1%	1%	2%
Хүнс	10%	13%	22%
Даавуу	3%	5%	3%
Цахилгаан бараа	0%	0%	4%
Зай	0%	0%	0%
Ариун цэврийн төрлийн	2%	13%	5%
Үнс	15%	7%	14%
Бусад	7%	11%	1%

Орлогын түвшнээс хамаарсан хаягдлын дундаж хувь хэмжээг хаягдлын ангиллаар харуулсан хүснэгт

Ахуйн хаягдлын хэмжээ өрхийн орон сууцны төрлөөс хамаарах нь

Өрхүүд байшинд (дунджаар 3.7 кг хаягдал) эсвэл гэрт (дунджаар 4 кг хаягдал) амьдардаг нь тэдний ахуйн хаягдалд хэрхэн нөлөөлдгийг олж мэдэхийн тулд уг асуулгыг судлагаандаа багтаасан юм. Гэсэн хэдий ч судлагаанд оролцсон нийт өрхүүдийн зөвхөн 3 (нийт түүврийн 8%) нь гэрт амьдардаг байсан тул энэ ангиллын тоо, мэдээлэл нийт Хишиг-Өндөр сумыг төлөөлж чадахгүй мөн эцсийн байдлаар дүгнэлт хийхэд хангалтгүй гэж үзлээ. Асуулгын хариултыг доорх хүснэгтээс харна уу.

Орон сууцны төрөл	Байшин	Гэр
Цаас	6%	4%
Хуванцар сав (PET)	9%	12%
Хатуу хуванцар	3%	1%
Гялгар уут	8%	10%
Тетрапак	0%	0%
Шил	26%	36%
Төмөр	1%	0%
Хүнс	12%	27%
Даавуу	4%	0%
Цахилгаан бараа	1%	0%
Зай	0%	0%
Ариун цэврийн төрлийн	8%	6%
Үнс	12%	2%
Бусад	9%	1%

Орон байрны төрлөөс хамаарсан хаягдлын дундаж хувь хэмжээг хаягдлын ангиллаар харуулсан хүснэгт

ДҮГНЭЛТ

2019 оны 7-р сард Хишиг-Өндөр суманд хийгдсэн ахуйн хаягдлын бүтцийн энэхүү судлагаанд сумын төвийн нийт өрхүүдийн 10% нь оролцсоноос дараах дүгнэлтүүдийг онцлон дурдаж байна. Үүнд:

- Өрх бүрийн долоо хоногт гаргадаг ахуйн хаягдлын дундаж хэмжээ нь 3.7кг байсан нь нэг хүн дунджаар өдөрт 160гр хаягдал гаргадаг гэсэн үг юм. Уг тоог сумын хэмжээнд авч үзвэл жилд 70 орчим тонн хаягдал гардаг ажээ.
- Шил болон хуванцар хаягдал нийт хаягдлын бараг тал буюу 47%-ийг эзэлж байна. Тиймээс хог хаягдлын менежментийг сайжруулах асуудалд энэ төрлийн хаягдлыг чухалчилан үзэх хэрэгтэй.
- Хүнсний хаягдал нийт ахуйн хаягдлын 14%-ийг эзэлж байсан нь хот суурингаас гардаг хүнсний хаягдлаас (Жишээ нь Улаанбаатар хотын гэр хорооллын нийт ахуйн хаягдлын 43%, орон сууцны ахуйн хаягдлын 78% нь хүнсний хаягдал) харьцангуй бага байсан юм.⁴
- Нярай хүүхэдтэй өрхүүдийн хувьд хамгийн их хэмжээгээр гардаг хаягдал нь хүүхдийн живх байсан бөгөөд нийт ахуйн хаягдлын тал орчим хувийг эзэлж байна.
- Зуны цагт үнсний хаягдал тийм ч тулгамдсан асуудал биш бөгөөд нийт ахуйн хаягдлын зөвхөн 11%-ийг эзэлж байна. Дээр нь зуны улиралд гарсан үнс ихэнхдээ мод, аргалын үнс байдаг ба өвлийн улиралын нүүрсний үнстэй харьцуулахад бохирдуулагч бараг байхгүй.
- Малын ялгадас, ялангуяа үхрийн аргалан хаягдал маш цөөн тооны өрхөөс гарсан ч түлшний зорилгоор дахин ашиглагддаг, ядаж л зуны улиралд сумын төвд хог тарьдаггүй гэдэг үүднээс хаягдал гэж ангилах нь зохисгүй гэж үзэв.
- Өрхийн орлого ихсэх тусам тухайн өрхөөс гарах хаягдлын хэмжээ багасч байв. Жишээ нь жилд 5 сая төгрөгөөс бага орлоготой өрх (нэг хүнд долоо хоногт 1.2 кг хаягдал) нь жилд 10 сая төгрөгөөс их орлоготой өрхөөс (нэг хүнд долоо хоногт 0.8 кг хаягдал) даруй 50% их хаягдал гаргаж байв.
- Орлого өндөртэй өрхүүд нь орлого багатай өрхүүдтэй харьцуулахад шилний хаягдал харьцангуй бага байсан бол хүнсний болон цахилгаан барааны хаягдал нь эсрэгээрээ их байсан ба хаягдлын бусад ангилалаас энэ баримт ажиглагдаагүй болно.

⁴ Батхуяг (E.U) болон бусад., Улаанбаатар хотын ахуйн болон үнсний хаягдлын онцлог, *Монгол Улс*, 2016 он.